



Бүгд Найрамдах Монгол Ард Улсын

Сайд нарын Зөвлөлийн

ТОГТООЛ

1953 оны 4 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 117

Улаанбаатар
хот

Улаанбаатар хотын Гүйцэтгэх Захиргааны
дэргэд байнга ажиллах комиссуудыг
байгуулах тухай

Б.Н.М.А.Улсын Сайд нарын Зөвлөлөөс Т О Г Т О О Х нь:

1.Одоо байгаа секцүүдийн оронд байнга ажиллах
комиссуудыг байгуулах тухай Улаанбаатар хотын Гүйцэтгэх
Захиргааны санаачлагыг сайшаасугай.

2.Байгуулагдах комиссуудын ажилд ажил хэргийн чанар-
тай туслалцаа үзүүлж, ахлын практикийг судлан нөгтгөхийг
хотын Гүйцэтгэх Захиргаатай хамтран гүйцэтгэхийг Сайд нар-
ын Зөвлөлийн Зохион Зааварлах хэлтэст даалгасугай.

3.Аймаг сумдын Гүйцэтгэх Захиргааны дэргэдэх одоо
байгаа секцүүдийн оронд комиссуудыг байгуулах тухайн санал-
ыг боловсруулж, энэ оны 7 дугаар сарын 10-ны өдөр Сайд
нарын Зөвлөлд оруулахыг Зохион Зааварлах хэлтэст даалга-
сугай.

ЕРӨНХИЙ САЙД

ХЭРЭГ ЭРХЛЭХ

ГАЗРЫН ДАРГА



/ЦЭДЭНБАЛ/

/БАДАРЧ/